

17 01 02

Б/01

Ц.Сэвжидмаад ажил хавсран
гүйцэтгүүлэх тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Хөдөлмөрийн тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.1. мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ажлыг 2017 оны 01 сарын 02-ний өдрөөс эхлэн Эрүүл мэндийн төвийн их эмч Ц.Сэвжидмаад түр хугацаагаар хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц. Сэвжидмаад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 20%-тай тэнцэх хэмжээгээр тооцож томилогдсон өдрөөс эхлэн олгохыг ня-бо Д. Бямба-Очирт зөвшөөрсүгэй.

3. Хавсран гүйцэтгэж байгаа ажлаа үндсэн ажлын нэгэн адил чанартай хийж, хууль тогтоомж, эрүүл мэндийн ажилтны ёс зүйн хэм хэмжээний дүрмийг чанд баримтлан ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч их эмч Ц. Сэвжидмаад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


С.БАЙГАЛЬМАА

07000001



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ТӨСВИЙН ШУЛГАГАЧ
УЛСЫН ТӨСВИЙН ХАМГААЛАГЧ

17 01 13

17/02

Үнэлгээний хороо байгуулах тухай

“Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 461.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнсний талоны эрхийн бичгээр үйлчлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчид: Г. Болормаа/Тамгын газрын дарга/

Гишүүдэд: Р. Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/

Н.Бодьсад /Байгаль хамгаалагч/

Г.Түмэнжаргал/Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн/

Н. Энхцэцэг/Нийгмийн даатгалын улсын байцаагч/

2. Хүнсний талоны эрхийн бичгээр үйлчлэх хүнсний дэлгүүрийг сонгон шалгаруулах ажлыг хууль журамд нийцүүлэн шударгаар зохион байгуулж, дүн мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг үнэлгээний хороо /Г.Болормаа /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАЙГАЛЬМАА

12 01 13

A/05

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт болон мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 19 өдрийн 13 дугаар тоот тогтоолоор батлагдсан 2017 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хуримт багийн иргэн Даваадоржийн Наянбууд “Цахиуртын Ганганы цахир толгойн бууц”-ыг хаваржааны зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшигч иргэн Д.Наянбуутай газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээжүүлэхийг газрын даамал Ж.Баасанцэрэнд үүрэг болгосугай.
3. Гэрээнд тусгагдсан нөхцлүүдийг хэрэгжүүлж ажиллахыг газар эзэмшигч иргэн Д.Наянбууд зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАЙГАЛЬМАА

0709000

17 02 07

А/с/4

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай

Ажлын хэсгийн ахлагч : Г. Болормаа /Засаг даргын Тамгын газрын дарга /

Гишүүдэд: Ч. Оюунгэрэл /Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Р. Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/

Ч.Гансүх /Байгаль орчны улсын байцаагч/

Б. Энхчимэг/МЭҮТ-ийн дарга/

М. Цэнд-Аюуш/МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Н. Энхцэцэг/Нийгмийн даатгалын байцаагч/

Г. Цогтгэрэл/Хуримт багийн Засаг дарга/

Д. Отгонбаатар/Галуут багийн Засаг дарга/

Я. Нямдорж /Далан багийн Засаг дарга/

Ш. Даваасүрэн/Сургуулийн захирал/

Д. Оюунбилэг/Цэцэрлэгийн эрхлэгч/

Г. Нармандах/Соёлын төвийн эрхлэгч/

Ц. Сэвжидмаа/Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг хавсран

гүйцэтгэгч/

Э. Одбаатар /Хэсгийн төлөөлөгч/

2. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аж ахуй нэгж байгууллага, ард иргэдээс санал авч, дээд шатны хөтөлбөр төсөл, бодлогын баримт бичигт тулгуурлан сайтар боловсруулалт хийж ажиллахыг ажлын хэсэг /Г. Болормаад /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

0700007

C:/My document/ZDAD/

17 02 07

А/05

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, мөн хуулийн 29.1.6./5/, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай

Ажлын хэсгийн ахлагч : Г. Болормаа /ЗДТГ-ын дарга /

Гишүүдэд: Р. Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/

Ч.Гансүх /Байгаль орчны улсын байцаагч/

Б. Энхчимэг/МЭҮТ-ийн дарга/

М. Цэнд-Аюуш/МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Р. Бурмаа /Цаг уурын ажиглагч /

Ш. Даваасүрэн/Сургуулийн захирал/

Д. Оюунбилэг/Цэцэрлэгийн эрхлэгч/

Г. Нармандах/Соёлын төвийн эрхлэгч/

Ц.Сэвжидмаа/Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг

хавсран гүйцэтгэгч/

Э. Одбаатар /Хэсгийн төлөөлөгч

2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг холбогдох заавар журмын дагуу гамшгийн төрөл тус бүрээр нарийвчлан боловсруулж, заасан хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэхийг ажлын хэсэг /Г. Болормаад /-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ЦЭДЭВСҮРЭН

0700005

17 02 07

1/00

Ажлын хэсэг байгуулах тухай

"Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нэг сум - Нэг үйлдвэр" хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд тус сумд шинээр байгуулах шаардлагатай жижиг дунд үйлдвэрийн талаар санал боловсруулах судалгааны багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Болормаа /ЗДТГ-ын дарга /

Гишүүдэд: Ч.Гансүх /Байгаль орчны улсын байцаагч/

Б. Энхчимэг/МЭҮТ-ийн дарга/

М. Цэнд-Аюуш/МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Ж.Баасанцэрэн/Газрын даамал/

П.Ундрах/НЭМ-ийн арга зүйч/


Г. Цогтгэрэл/Хуримт багийн Засаг дарга/

Д. Отгонбаатар/Галуут багийн Засаг дарга/

Я. Нямдорж /Далан багийн Засаг дарга/

2. Шинээр байгуулах үйлдвэрийн судалгааг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, гарсан саналыг 02 сарын 10-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсэг /Г.Болормаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

07000000

17 02 09

1/07

Асран хамгаалагчаар тогтоох тухай

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Хуримт багийн иргэн Лхамжавын Ичинноров нь умайн хүзүүний хорт хавдартай, нойр булчирхайн үрэвсэлт өвчний улмаас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настаны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Лхамжавын Ичинноровийн асран хамгаалагч нь хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн Чойжоохүүгийн Баяраа мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ЦЭДЭВСҮРЭН

0700010

17 02 09

А/08

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 25.1.11 дэх заалт болон Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Орон нутагт "Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын ажлын хэсгийн ахлагч: /Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

Гишүүд: Эрүүл мэндийн нийгмийн ажилтан

Сургуулийн нийгмийн ажилтан

Улсын бүртгэгч

Хуримт багийн засаг дарга

Галуут багийн засаг дарга

Далан багийн засаг дарга

Хэсгийн төлөөлөгч

2. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлж, ажиллахыг ажлын хэсэг /Тамгын газрын дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

В. ЦЭДЭВСҮРЭН

0700013

17 02 14

1/09

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2 Хүнсний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цагаан сар”-ын баяртай холбогдуулан хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай

Ажлын хэсгийн ахлагч: Б.Энхчимэг /МЭҮТ-ийн дарга/

Гишүүдэд: М.Цэнд-Аюуш /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Э.Одбаатар /Хэсгийн төлөөлөгч а/д/

Д.Баатарцогт /Цагдаа/

Ч.Гансүх /Байгаль орчны улсын байцаагч/

2. Хяналт шалгалтын удирдамжийг хавсралтаар баталсугай

3.Хяналт шалгалтыг удирдамжийн дагуу чанартай хийж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн, дүн мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж холбогдох дээд газарт хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч /Б.Энхчимэг/-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

0700015

Сумын Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 14/02 дугаар захирамжийн хавсралт

“ЦАГААН САР” НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХҮНСНИЙ ДЭЛГҮҮРҮҮДЭД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2017.02.14

Цагаан-Олом

Нэг: Зорилго

“Хүнсний тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүнсний дэлгүүрийн үйл ажиллагаа, үйлчилгээг чанартай үр дүнтэй болгохын тулд хүнсний дэлгүүрийн стандарт хэрэгжилтийг шалган үйл ажиллагааг сайжруулахад оршино.

Хоёр: Хяналтын чиглэл

1. Хүнсний дэлгүүрүүд MNS5021:2007 стандарт шаардлагыг хэрхэн хангаж байгааг хавсралт хүснэгтийн дагуу гаргах
2. Хүнсний дэлгүүрүүдийг “Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 16,2,5, “Хүнсний тухай” хуулийн 9,1,2 дахь заалтын дагуу үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ба дүгнэлт гаргуулсан эсэхийг шалгах.
3. Хугацаа дууссан болон чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа эсэх
4. Ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага ханган ажиллаж байгаа эсэх.

Гурав: Хамрагдах аж ахуй нэгж, байгууллагын нэр

“Од” хүнсний дэлгүүр, “Болор” хүнсний дэлгүүр, “Эх наран” хүнсний дэлгүүр хамрагдана.

Дөрөв: Хяналтыг хийх хугацаа:

017 оны 02 дугаар сарын 7-ны өдрөөс 2017оны 02 сарын 15-ныг хүртэл ажлын 07 хоногт хийж дуусна

Тав: Дүнг нэгтгэн тайлагнах

Ажлын хэсгийн ахлагч дүнг нэгтгэн илтгэх хуудсаар Засаг даргад танилцуулж дүн мэдээг 2 сарын 24-ны дотор МХГазарт хүргүүлэх.

17 62 15

1/10


Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хуримт багийн иргэн Норовын Лхамхүү нь бамбай булчирхай, цөс, савны хагалгаанд орж саваа авхуулсан, мөн өвдөгний үений хурц үрэвсэл, даралт ихэддэг шалтгааны улмаас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настаны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Норовын Лхамхүү асран хамгаалагч нь хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн Сүхбаатарын Алтанцэцэг мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0700007

17 02 21

A/11

Хөрөнгө зарцуулах тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт нийтлэг журмын 2 дугаар хэсгийн 2.1.3 дахь заалт болон сумын сайн малчны журмын болзол, сумын Засаг даргын шагналын журам, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан сумын сайн малчны болзол хангасан нэр бүхий 11 хүнийг “Сумын аварга малчин”-аар шалгаруулж, өргөмжлөл, энгэрийн тэмдэг, мөнгөн шагналаар шагнаж 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Өнгөрч буй 2016 онд ажил үйлсээрээ тэргүүлсэн тэргүүний хүмүүсийг сумын Засаг даргын шагналаар шагнаж 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Тус сумын 65-аас дээш настай нэр бүхий 40 ахмад настанд сумын Засаг даргын гарын бэлэг олгоход зориулж 400,0 төгрөгийг зарцуулсугай.

4. Сар шинийн билгийн тооллын цагаан сарын баярын нийтийн золголтонд зориулах хүндэтгэлийн тавгийн идээний зүйлд 182.0 төгрөгийг зарцуулсугай.

5. Дээрх зардалд зарцуулагдах нийт 2032.0 төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг ня-бо /Д. Бямба-Очир/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

0700019

17 02 23


А/12

Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Галуут багийн иргэн Чилхаагийн Ойдов нь түрүү булчирхайн хавдар, гэмтлийн улмаас зүүн талын 4 хавирга хугарч зөрж эдгэсэн, даралт ихэддэг зэрэг шалтгааны улмаас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Чилхаагийн Ойдовын асран хамгаалагч нь хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн бэр Бат-Очирын Отгонбаяр мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

07000000

Сумын Засаг даргын 2017 оны...⁰² дугаар сарын...⁰¹ны
 өдрийн ...⁰¹ дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

Сумын аварга малчны шагнал

№	Шагналын зориулалт	Хэнд олгох	Олгох мөнгөн шагнал	ХАОАТ	Өргөмжлөл	Энгэрийн тэмдэг	Жинхэнэ олгох
1	Сумын сайн малчин	П. Амгаланбаатар	100000	10%	10000	12000	68000
2	Сумын сайн малчин	А. Пүрэвсүрэн	100000	10%	10000	12000	68000
3	Сумын сайн малчин	С. Бямбадорж	100000	10%	10000	12000	68000
4	Сумын сайн малчин	Д. Дагдансүрэн	100000	10%	10000	12000	68000
5	Сумын сайн малчин	Д. Ганбаатар	100000	10%	10000	12000	68000
6	Сумын сайн малчин	Х. Сандагдорж	100000	10%	10000	12000	68000
7	Сумын сайн малчин	Н. Пүрэвдорж	100000	10%	10000	12000	68000
8	Сумын сайн малчин	Н. Дагвадорж	100000	10%	10000	12000	68000
9	Сумын сайн малчин	Д. Доржсүрэн	100000	10%	10000	12000	68000
10	Сумын сайн малчин	Г. Одонбаатар	100000	10%	10000	12000	68000
11	Сумын сайн малчин	О. Гаравдорж	100000	10%	10000	12000	68000
			1100000		110000	132000	748000

Сумын Засаг даргын 2017 оны... дугаар сарын...ны
 өдрийн... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Тэргүүний хүмүүст олгосон шагнал

№	Шагналын зориулалт	Хэнд олгох	Олгох мөнгөн шагнал	ХАОАТ	Өргөмжлөл	Энгэрийн тэмдэг	Жинхэнэ олгох
1	Засаг даргын шагнал	Р. Бүрэнжаргал	50000	10%	10000		35000
2	Засаг даргын шагнал	Д. Цэвгээ	50000	10%	10000		35000
3	Засаг даргын шагнал	Э. Одбаатар	50000	10%	10000		35000
4	Засаг даргын шагнал	А. Нямлхагва	50000	10%	10000		35000
5	Тэргүүний хамт олон	Бүрэн дунд сургууль	50000	10%	10000		35000
6	Сумын аварга саальчин	Цэцэгмаа	50000	10%	10000		35000
7	Засаг даргын шагнал	Б. Дагванамжил	50000	10%	10000		35000
8			350000		70000		245000

17 02 24

A/13

Сар шинийн баяр амралтын өдрүүдэд
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай


"Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. болон 29.1.6 Б заалт, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний цагаан сарын баярын үеэр сумын холбооны салбар, ундны усны худгийн ашиглалт, цахилгаан дулааны хангамж зэрэг онцгой объектуудыг хэвийн үйл ажиллагаа, нийгмийн хэвийн журам хангахад хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий сумын хариуцлагатай эргүүлийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Баярын болон нийтээр амрах амралтын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурах, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, ард иргэдийн амар тайван баярлах, амрах нөхцлийг хангаж ажиллахыг хэсгийн төлөөлөгч ахлах дэслэгч / Э.Одбаатар/ болон хэсгийн цагдаа ахлагч /Б.Баатарцогт/ нарт дааргасугай.

3. Энэ захирамжийн биелэлтэнд хяналт тавьж, дүнг 03 сарын 10-ны өдөр сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хэсгийн төлөөлөгч а/д /Э.Одбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭДЭВСҮРЭН

0700015

Сумын Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24 ны
өдрийн 1/13 дугаар захирамжийн хавсралт

СУМЫН ХАРИУЦЛАГАТАЙ ЭРГҮҮЛИЙН
АЖИЛЛАХ ХУВААРЬ

№	Эргүүлийн нэрс	Албан тушаал	Эргүүлд гарах он, сар, өдөр	Гарын үсэг
1.	Ц.Сэвжидмаа	ЭМТ-ийн эрхлэгч, их эмчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	2017.02.26	
	Б.Баатарцогт	Хэсгийн цагдаа		
2.	Б.Нармандах	Соёлийн төвийн эрхлэгч	2017.02.27	
	Э.Одбаатар	Хэсгийн төлөөлөгч		
3.	Б.Баатарцогт	Хэсгийн цагдаа	2017.02.28	
	Ш.Даваасүрэн	Сургуулийн захирал		
4.	Э.Одбаатар	Хэсгийн төлөөлөгч	2017.03.01	
	Д.Оюунбилэг	Цэцэрлэгийн эрхлэгч		

17 03 06

1/14

Гэрээ байгуулах эрх олгох тухай

“Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг “Босго үнэ шинэчлэн батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын Соёлын төвд тоног төхөөрөмж шууд худалдан авах эрхийг Соёлын төвийн эрхлэгч Г.Нармандахад олгосугай.

2. Соёлын төвд тоног төхөөрөмж шууд худалдан авах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн, шуурхай санхүүжүүлж ажиллахыг төрийн сангийн төлөөлөгч Р.Бүрэнжаргалд үүрэг болгосугай.

3. Соёлын төвд чанар стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжийг баталгаатай бараа материал нийлүүлдэг мэргэжлийн байгууллагаас худалдан авахыг Соёлын төвийн эрхлэгч Г. Нармандахад зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

07000000

17 03 07


1/15

Комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. болон “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 26 дугаар зүйлийн 26.1. дэх хэсэг, “Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай” Засгийн газрын 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 1 дэх хэсгийн 1.3.-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын онцгой комиссын гишүүдийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, онцгой комиссын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Онцгой комиссын гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, тухай бүрт нь үүрэгжүүлж ажиллахыг Онцгой комиссын орлогч дарга, сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Болормаад даалгасугай.
3. Сумын онцгой комиссын гишүүдэд дуудсан цагт бэлэн байж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний талаар дарга, удирдлагуудаас өгсөн үүргийг ягштал биелүүлж, хариу мэдээлж байхыг үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭДЭВСҮРЭН

Сумын Засаг даргын 2017 оны 03 дүгээр сарын 07-ны
өдрийн 11/15 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Онцгой комиссын дарга: Сумын Засаг дарга

Онцгой комиссын орлогч дарга: Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд: Сумын Засаг даргын орлогч

Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга

Санхүүгийн албаны дарга

Дотоод ажил хариуцсан түшмэл

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч

МЭҮТ-ийн газар тариалан, хоршоо ЖДҮ хариуцсан мэргэжилтэн

Сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

Соёлын төвийн захирал

Холбооны салбарын ажилтан

Цаг уурын харуул

Усны харуул

Байгаль орчны мэргэжилтэн

Газрын даамал

“Алтай-Улиастай” эрчим хүчний станцын харуулын ахлагч

Холбооны салбарын эрхлэгч

~~Цаг уурын станцын харуул~~

“Зост-Өндөр” ХХК-ний захирал

Хуримт багийн Засаг дарга

Галуут багийн Засаг дарга

Далан багийн Засаг дарга

Сумын Засаг даргын 2017 оны 03 дүгээр сарын 07-ны
өдрийн 1/15 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Сумын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг сумын Засаг дарга батална.
- 1.2. Сумын Онцгой комисс /цаашид комисс гэх/ нь Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.
- 1.3. Сумын онцгой комиссын дарга нь Засаг дарга, орлогч дарга нь ЗДТГ-ын дарга байна.
- 1.4. Комиссын хурал нийт гишүүдийн 60-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл гаргана.
- 1.5. Комиссын дарга нь холбогдох хууль тогтоомжоор олгогдсон үүрэг, зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар захирамж гаргана.
- 1.6. Комиссоос гаргасан шийдвэрийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.
- 1.7. Комиссын өдөр тутмын үйл ажиллагааг сумын Онцгой комиссын орлогч дарга эрхэлнэ.

Хоёр: Комиссын эрх, үүрэг

- 2.1. Сумын онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, аймгийн онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангах үүрэгтэй ажиллана.
- 2.2. Сумын онцгой комисс нь аймгийн онцгой комиссын ажиллах журмын 11-т заасан үүргийг биелүүлэн 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5-т заасан эрхийг эдэлнэ.
- 2.3. Гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүч хүрэлцэхгүй болсон үед дээд шатны Онцгой комисст албан ёсны хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.
- 2.4. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн захиргааны

болон аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах гүйцэтгэлтэнд нь хяналт тавина.

2.5. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд орон нутгийн төрийн байгууллага болон ААН, албан тушаалтан, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл хэлбэр үл харгалзан татан оролцуулна.

2.6. Холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ мэдээлэл судалгаа гаргуулан авах, илтгэл мэдээллийг хурлаараа хэлэлцэж шийдвэр гарган биелүүлэхийг шаардах эрхтэй.

2.7. Сумын онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссан тухай бүр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийхээ тайланг жил бүрийн 11 дүгээр сард багтаан аймгийн онцгой комисст танилцуулна.

2.8. Сумын онцгой комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу захиран зарцуулж, зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр аймгийн ОБХэлтэс /онцгой комисс/-т ирүүлж байна.

Гурав: Комиссын зардал

3.1. Комисс нь нутаг дэвсгэртээ гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хөрөнгө, зардлыг жилийн төсөвтөө тусган зохих журмын дагуу захиран зарцуулна.

3.2. Комиссын тухайн үеийн үйл ажиллагааны зардлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан тооцоо, Санхүү эдийн засгийн бодлого зохицуулах хэлтсийн саналыг үндэслэн Засаг даргын нөөц хөрөнгө, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

Дөрөв: Бусад зүйл

4.1. Сум дүүргийн онцгой комисс нь гамшгийн үед зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнг гамшгийн нөхцөл байдал дууссаны дараа тухай бүр аймаг, онцгой комисст ирүүлнэ.

4.2. Өгсөн үүрэг даалгаварыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнд захиргааны шийтгэл ногдуулах, саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

17 03 09

1/16

Гамшгаас хамгаалах мэргэжлийн
ангийг шинэчлэн байгуулах тухай

“Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. болон “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.2. дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.3. дахь заалт, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 07 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм”-ийн 1 дүгээр бүлгийн 1.3. болон 2 дугаар бүлгийн 2.3. дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний томилгоог тухай бүр тодотгон баталгаажуулж, өдөр тутмын удирдлагаар хангах, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвар эзэмшүүлэх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний үеэр үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах талаар хууль, дүрэмд заасан эрх, үүргээ хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний дарга Г.Болормаад даалгасугай.

3. Сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхийг сайжруулах, гамшгийн бэлэн байдлыг хангуулах талаар мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг чиглэлийг бүрэн гүйцэтгэж ажиллахыг бүлгүүдийн ахлагч нар болон гишүүдэд үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/28 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭДЭВСҮРЭН

07000001

Сумын Засаг даргын 2017 оны 03 дүгээр сарын 09-ны
өдрийн 1/16 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралт

Тайшир сумын гамшгаас хамгаалах
мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүн

Мэргэжлийн ангийн даргад: Г.Болормаа /Тамгын газрын дарга/

Мэргэжлийн ангийн орлогч дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны
даргад: Д.Бямба-Очир /ЗДТГ-ын нягтлан бодогч/

Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтанд: Д.Цолмон /Холбооны салбарын
ажилтан/

Сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтанд: Ш.Даваасүрэн /Сургуулийн захирал/

Гамшгаас хамгаалах нөөц, хангалт хариуцсан ажилтанд: Р.Бүрэнжаргал /ЗДТГ-ын
санхүүгийн албаны дарга/

Хүн эмнэлгийн үйлчилгээ хариуцсан ажилтанд: Ц.Сэвжидмаа /Эрүүл мэндийн
төвийн их эмч/

Сэргээн босголтын асуудал хариуцсан ажилтанд: Ч.Гансүх /Байгаль орчны улсын
байцаагч/

Аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтанд: Т.Жавзандулам /Нийгмийн
даатгалын байцаагч/

Хэв журмын асуудал хариуцсан ажилтанд: Э.Одбаатар /Хэсгийн төлөөлөгч/

-----oO-----

Сумын Засаг даргын ²⁰¹⁷ оны ⁰³ дүгээр сарын ⁰⁹ -ны өдрийн ^{2/16} дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн

Шуурхай командын бүрэлдэхүүн	Хүний тоо	Д/д	Томилгоожуулалт
Шуурхай командын дарга	1	1	Гармаагийн Болормаа
Хангалт эрхэлсэн орлогч	1	2	Дамдиндоржийн Бямба-Очир
Нэг. АВРАХ БҮЛЭГ			
Бүлгийн дарга	1	3	Чойжинсүрэнгийн Гансүх
Жолооч	2	4	Содномбалжирын Баянмөнх
		5	Чулуунбатын Дашдорж
Аврагч нар	22	6	Гүндээгийн Цогтгэрэл
		7	Даваахүүгийн Ганбаатар
		8	Балдандоржийн Ганбат
		9	Баатарсүрэнгийн Нармандах
		10	Ядамын Аюуш
		11	Вандангийн Нарангэрэл
		12	Хишигбаяр Атарцэцэг
		13	Дагваагийн Ганбаатар
		14	Ванданмагсарын Бизъяа
		15	Дорждэрэмийн Батмөнх
		16	Нордовын Бодьсад
		17	Дагванамжилын Адъяасүрэн
		18	Дагваагийн Хатанбаатар
		19	Пүрвээгийн Ганболд
		20	Гэлэгбаатарын Жамбал
21	Энхтүвшингийн Баярсайхан		
22	Лувсандоржийн Энхтүвшин		
23	Цанжид Должинжав		
24	Доржсэмбийн Байгальмаа		
25	Цэндсүрэнгийн Болдсайхан		
26	Дагваагийн Эрдэнэбаатар		
27	Мөнхбатын Цэнд-Аюуш		
ХОЁР. МЕХАНИКУЖУУЛСАН БҮЛЭГ			
Хэсгийн ахлагч	1	28	Доржсэмбийн Түмбаатар
Гагнуурчин	1	29	Дагваагийн Төмөрбаатар
Токарьчин	2	30	Гүндээгийн Батгэрэл
		31	Гүндээгийн Алтангэрэл
Цахилгаанчин	2	32	Чулуунбатын Эрдэнэбаатар
		33	Пэрэнлэйн Мөнхбаатар
Сантехникийн слесарь	2	34	Даш-Очирын Төмөрхуяг
		35	Баатарын Дагванамжил

Бульдозерчин	1	36	Тэгшжаргалын Батсайхан
Жолооч	1	37	Лувсансамдангийн Наранбаатар
ГУРАВ. ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ БҮЛЭГ			
Хэсгийн ахлагч	1	38	Лувсандоржийн Ганхуяг
Цагдаа	2	39	Дашдоржийн Баатарцогт
		40	Рэнцэндоржийн Лхамдулам
Идэвхтнүүд	5	41	Чойжоохүүгийн Оюунгэрэл
		42	Дашцэрэнгийн Оюунбилэг
		43	Төмөрбаатарын Жавзандулам
		44	Равдангийн Бурмаа
		45	Пүрэвийн Ундрах
ДӨРӨВ. ЭМНЭЛГИЙН БҮЛЭГ			
Хэсгийн ахлагч	1	46	Найдангийн Онон
Эмч	1	47	Төмөрбаатарын Лхамзүмбэрэл
Сувилагч	2	48	Дашзэгвийн Наранбадам
		49	Магсарын Байгальмаа
Асрагч	2	50	Пүрэвийн Алтанцэцэг
		51	Гүргэнжавын Батсуурь
Жолооч	1	52	Лувсандоржийн Дашравдан
ТАВ. САЙН ДУРЫН БҮЛЭГ			
Нөхөрлөлийн дарга	1	53	Баасангийн Мөнхсоёл
Ухуулагч	1	54	Цэрэнбалдангийн Цэвээндулам
Жолооч, холбоочин	1	55	Дагваагийн Батбаатар
Идэвхтнүүд	12	56	Лувсанбатаа Мөнгөн-Өлзий
		57	Дагвадоржийн Оюунсүвд
		58	Гэлэнгийн Лхамбүтэд
		59	Ганбатын Нандин-Эрдэнэ
		60	Гүндээгийн Алтанцэцэг
		61	Банзрагчийн Нарантунгалаг
		62	Гүргэнжавын Батсуурь
		63	Доржсэмбийн Отгон-Эрдэнэ
		64	Пүрэвийн Отгонцэцэг
		65	Лхагвасүрэнгийн Доржханд
		66	Жаргалсайханы Мядагмаа
67	Ванданмагсарын Энхтуяа		

17 03 10

А/17

Гамшгаас хамгаалах орон тооны бус
албадыг шинэчлэн байгуулах тухай


“Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2. болон “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 26.1.3. дахь заалт, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 07 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэм”-ийн 1 дүгээр бүлгийн 1.3. болон 2 дугаар бүлгийн 2.4. дахь хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын гамшгаас хамгаалах тусгай зориулалтын орон тооны бус мэргэжлийн алба болох Хүнс хөдөө аж ахуйн болон Эрүүл мэндийн албадын бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулж, хавсралтаар тогтоосугай.

2. Гамшгаас хамгаалах орон тооны бус албадын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх мэргэжлийн чиг үүрэг, малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Эрүүл мэндийн албаны дарга их эмч Ц.Сэвжидмаа, Хүнс хөдөө аж ахуйн албаны дарга, Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга Б.Энхчимэг нарт үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах орон тооны бус албадын гүйцэтгэх үүрэг чиглэлийг тодорхой болгож, ерөнхий удирдлагаар хангаж ажиллахыг сумын онцгой комиссын орлогч, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүний дарга Г.Болормаад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЦЭДЭВСҮРЭН

0700000

Сумын Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 4/17 дугаар захирамжийн хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ОРОН ТООНЫ БУС АЛБА,
НАРИЙН МЭРГЭЖЛИЙН АНГИУДЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Албадын нэр	Бүтэц бүрэлдэхүүн, томилгоожуулалт	Шаардлагатай техник, тоног төхөөрөмж
<p>Эрүүл мэндийн алба: Дарга: Эрүүл мэндийн төвийн дарга</p>	<p>Орон тоо-9 Дарга: Их эмч Ц.Сэвжидмаа Бага эмч-1: Т.Лхамзүмбэрэл Нийгмийн ажилтан-1 П.Ундрах Сувилагч-2: Э.Баярсайхан М.Байгальмаа Асрагч-2: П.Алтанцэцэг Г.Батсуурь Жор баригч-1: Г.Нандин-Эрдэнэ Жолооч, холбоочин-1: Л.Дашравдан</p>	<p>Тоноглогдсон зориулалтын авто машин -1 Шаардлагатай багаж, тоног төхөөрөмж- 1 ком Яаралтай тусламжийн иж бүрдэл-2ш Явуулын аптека-1ком Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл-9 Автомакс-2</p>
<p>Хүнс, хөдөө аж ахуйн алба Дарга: МЭҮТ-ийн дарга</p>	<p>Орон тоо-:6 Дарга, Малын их эмч-1: Б.Энхчимэг Малын бага эмч-2: Д.Дорж Э.Наранцэцэг Агрономич-1 М.Цэнд-Аюуш Ариутгагч-1: Ц.Болдсайхан Холбоочин, жолооч-1: Ч.Дашдорж</p>	<p>Авто машин-1 Радио станц-1 Шаардлагатай багаж төхөөрөмж-1 ком Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл-3 Автомакс-2</p>

17 03 15

Б/18

Я. Нямдоржийг ажлаас чөлөөлөх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Далан багийн Засаг дарга Я. Нямдоржийг 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ээлжит сонгуулийн үр дүнгээр албан тушаалаас чөлөөлөгдөж байгаа багийн Засаг дарга Я. Нямдоржид холбогдох хууль тогтоомжид заасан тэтгэлэгийг төсөвт суугдсаны дараа тооцож олгохыг ня-бо Д. Бямба-Очирт зөвшөөрсүгэй.

3. Багийн засаг даргын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Г. Болормаа /ЗДТГ-ын дарга/

Гишүүдэд: Р Бүрэнжаргал/Санхүүгийн албаны дарга/

Ж. Баасанцэрэн/Нярав/

С. Батнасан/Багийн ИНХ-ын дарга/

Ч. Оюунгэрэл/ДАХмэргэжилтэн/

4. Багийн Засаг дарга нарын ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг ЗДТГ-ын ня-бо Д. Бямба-Очирт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

3-000-0

17 03 15

5/19


Г. Цогтгэрэлийг ажлаас чөлөөлөх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Хуримт багийн Засаг дарга Г. Цогтгэрэлийг 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Багийн Засаг дарга нарын ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг ЗДТГ-ын ня-бо Д. Бямба-Очирт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0700011

17 03 15

Б/20


Д. Отгонбаатарыг ажлаас чөлөөлөх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.2, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Галуут багийн Засаг дарга Д. Отгонбаатарыг 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Багийн Засаг дарга нарын ажлыг хүлээлцүүлж, холбогдох тооцоог хийж дуусгахыг ЗДТГ-ын ня-бо Д. Бямба-Очирт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0700013



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
ТӨР ИРГЭДИЙН ХУУЛЬ
ЗАСАГ ДАРГА

17 03 15

Б/21

Г.Цогтгэрэлийг ажилд томилох
тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1. дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хуримт багийн иргэдийн нийтийн хурлаас багийн Засаг даргад томилуулахаар уламжлагдаж байгаа Г.Цогтгэрэлийг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Хуримт багийн Засаг даргаар томилон ажиллуулсугай.

2. Багийн Засаг дарга Г.Цогтгэрэлийн үндсэн цалинг 478705 төгрөгөөр тогтоож, хууль тогтоомжид заасан нэмэгдлийн хамт томилогдсон өдрөөс тооцож олгохыг ня-бо Д.Бямба-Очирт даалгасугай.

3. Хариуцсан ажилдаа эзний ёсоор ажил хэрэгч хандаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийн дагуу хууль ёсыг чанд сахиж ажиллахыг багийн Засаг дарга Г.Цогтгэрэлд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬЧИЙН
ТӨР ИРГЭДНИЙ ЗАСАГ
ЗАСАГ ДАРГАЙН ЗУНГАГАМ

17 03 15

5/22

Д.Отгонбаатарын ажилд томилх
тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1. дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галуут багийн иргэдийн нийтийн хурлаас багийн Засаг даргад томилуулахаар уламжлагдаж байгаа Д.Отгонбаатарыг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Галуут багийн Засаг даргаар томилон ажиллуулсугай.

2. Багийн Засаг дарга Д.Отгонбаатарын үндсэн цалинг 478705 төгрөгөөр тогтоож, хууль тогтоомжид заасан нэмэгдлийн хамт томилогдсон өдрөөс тооцож олгохыг ня-бо Д.Бямба-Очирт даалгасугай.

3. Хариуцсан ажилдаа эзний ёсоор ажил хэрэгч хандаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийн дагуу хууль ёсыг чанд сахиж ажиллахыг багийн Засаг дарга Д.Отгонбаатарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ЦЭДЭВСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ХАМГААГАХ
ТӨР ИЙН АЛБАН
ЗАСАГ ДАРГА БИР ХАМГААГАХ

17 03 15

5/23

С.Баярсайханыг ажилд томилох
тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь заалт, “Төрийн албаны тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.1. дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Далан багийн иргэдийн нийтийн хурлаас багийн Засаг даргад томилуулахаар уламжлагдаж байгаа С.Баярсайханыг 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Далан багийн Засаг даргаар томилон ажиллуулсугай.

2. Багийн Засаг дарга С.Баярсайханы үндсэн цалинг 478705 төгрөгөөр тогтоож, хууль тогтоомжид заасан нэмэгдлийн хамт томилогдсон өдрөөс тооцож олгохыг ня-бо Д.Бямба-Очирт даалгасугай.

3. Хариуцсан ажилдаа эзний ёсоор ажил хэрэгч хандаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийн дагуу хууль ёсыг чанд сахиж ажиллахыг багийн Засаг дарга С.Баярсайханд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ЦЭДЭВСҮРЭН

17 03 15


А/24

Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Далан багийн иргэн Чойжингийн Дэмбэрэл нь нойр булчирхайн үрэвсэлт өвчний улмаас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настань асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2.Зээ охины хүү Г. Дамбийбалжир нь хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд асрамжлагч нь мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

1100101

17 03 15

1/25


Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хуримт багийн иргэн Чимэдцэрэнгийн Сумъяа нь даралт ихсэх 3 дугаар шатлалын өвчний улмаас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настаны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн бүл дүү О. Алтанцэцэг нь Чимэдцэрэнгийн Сумъяагийн асрамжлагч нь мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0709/04

17 03 15

А/26

Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын “Гэр бүлийн тухай” хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Галуут багийн иргэн Хандсүрэнгийн Пунцаг нь үе мөчний архаг үрэвсэлтэй, 2 чих дүлий хавсарсан оноштой учраас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настаны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2 Хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн зээ хүү Г. Жаргалсайхан нь Хандсүрэнгийн Пунцагийн асрамжлагч нь мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

17 03 15

1/27

Асран хамгаалагч тогтоох тухай

Монгол Улсын "Гэр бүлийн тухай" хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт болон "Нийгмийн халамжийн тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 19 дүгээр зүйлийн 1.1 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Галуут багийн иргэн Товуугийн Цэенрэгзэн нь үе мөчний архаг үрэвсэлтэй, суугаа учраас эмнэлгийн хяналтанд байдаг ба бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүйг нь харгалзан ахмад настаны асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхэлдэггүй иргэн Хүү Ц. Баасандаш нь Товуугийн Цэенрэгзэнгийн асрамжлагч нь мөн болохыг тогтоосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

17 03 21

А/28

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4В заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум орон нутгийг холбосон хатуу болон хайрган хучилттай авто замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Болормаа/Тамгын газрын дарга/

Гишүүдэд: Э.Одбаатар/Хэсгийн төлөөлөгч/

Д.Баатарцогт/Хэсгийн цагдаа/

Ж.Баасанцэрэн/Газрын даамал/

Ч.Дашдорж/ЗДТГ-ын жолооч/

2. Замын тэмдэг тэмдэглэгээнд үзлэг шалгалт хийж, тэмдэгжүүлэх шаардлагатай газрын судалгаа, байршлын зургийг гаргаж, нэгтгэн, дүн мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж 2017 оны 03 дугаар сарын 25-ны дотор аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт хүргүүлэхийг ажлын хэсэг / Э.Одбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

3700-770

17 03 21

А/29

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон
тооны бус зөвлөл байгуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн Л, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн даргад: Б. Энхчимэг /МЭҮТ-ийн дарга/

Гишүүдэд: Ч. Оюунгэрэл /Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/

Ч. Гансүх /Байгаль орчны улсын байцаагч/

С. Төмөрбаатар /Татварын улсын байцаагч/

М. Цэнд-Аюуш /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Э. Одбаатар /Хэсгийн төлөөлөгч /

Н. Даваахүү /Сургуулийн нийгмийн ажилтан/

2. Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд нийлүүлж, борлуулж байгаа бараа бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдалд тавих хяналтыг чангатгаж, гарсан зөрчлийг арилгуулах, хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хэрэглээний соёлын талаар сургалт зохион байгуулах зэрэг хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэг /Б. Энхчимэг/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ЦЭДЭВСҮРЭН

17 03 27

А/30

Ажлын хэсэг байгуулах тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/84 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг сумын хэмжээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Болормаа /Засаг даргын Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Н.Оюундэлгэр /ХХҮГ-ын мэргэжилтэн/

Гишүүд: Г.Цогтгэрэл-/Хуримт багийн Засаг дарга/

Д.Отгонбаатар-/Галуут багийн Засаг дарга/

С.Баярсайхан-/Далан багийн Засаг дарга/

Р.Бүрэнжаргал-/Төсөв, төрийн сангийн төлөөлөгч/

С.Төмөрбаатар -/Татварын улсын байцаагч/

Т.Жавзандулам-/Нийгмийн даатгалын байцаагч/



Р.Лхамдулам -/Иргэний бүртгэлийн мэргэжилтэн/

Э.Одбаатар-/Хэсгийн төлөөлөгч/

Д.Баатарцогт-/Цагдаа/

2. Мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулж дуусах хүртэлх хугацаанд байнгын ажиллагаатай байх нөхцлийг бүрдүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Болормаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б. ЦЭДЭВСҮРЭН

07000091

17 03 28

А/31

Архидан согтуурахтай тэмцэх тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, мөн хуулийн 9-р зүйлийн 9.1, мөн хуулийн 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Төрийн албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын цагаар, ажлын байранд архи согтууруулах ундаа хэрэглэж, сахилга, хариуцлага алдахыг хориглосугай.

2. Ажлын цагаар болон албан тасалгаанд, ажил үүргээ гүйцэтгэх явцдаа архи согтууруулах ундаа хэрэглэсэн төрийн албан хаагчийг ажлаас шууд халах хүртэл сахилгын арга хэмжээ авч байхыг төсөвт байгууллагын дарга эрхлэгчдэд даалгасугай.

3. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахиж, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийг хэрэгжүүлж ажиллахыг нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Сумын Засаг даргын захирамжийн биелэлтийг 7 хоног бүрийн 1дэх өдөр шуурхай зөвөлгөөнд мэдээлж байхыг Тамгын газрын дарга Г. Болормаад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0700097

17 13 30

A/32

Ажлын хэсэг байгуулах тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Төрийн болон орон нутгийн эмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн Соёлын төвийн техник хэрэгслийн ашиглалтын бэлэн байдалд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчид: Г.Болормаа /Тамгын газрын дарга /

Гишүүдэд: Р. Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/

Д.Байгальмаа /Номын санч/


Д.Адъяасүрэн /Нягтлан бодогч/

Д.Ганбаатар /Сургуулийн багш /

2. Соёлын төвийн техник хэрэгсэл нь ашиглаж болохуйц, чанарын шаардлага хангасан тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн эсэх, уг тоног төхөөрөмжийг хэрхэн суурилуулж, ашиглаж байгаа ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлгээ дүгнэлт өгч, хүлээн авах асуудлыг шийдвэрлэн, акт баримтыг бүрэн бүрдүүлж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг /Г.Болормаа/-д үүрэг болгосугай.

3. Соёлын төвийн техник хэрэгслийг байгууллагынхаа данс бүртгэлд авч, төсвийн орлого болгохыг Соёлын төвийн эрхлэгч Б. Нармандахад даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

1700199

17 04 03

1/33

Ажлын хэсэг байгуулах тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Төсвийн тухай” хуулийн 63 дугаар зүйлийн 63.3, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 244 дүгээр тушаалын 12 дугаар зүйлийн 12.2.5.в заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багийн ИНХ-аар иргэдийн эрэмбэлэгдсэн саналд тулгуурлан орон нутгийн хөгжлийн сангаас 2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчид: Г. Болормаа/Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: Р. Бүрэнжаргал/ Санхүүгийн албаны дарга/

Гишүүдэд: Д. Бямба-Очир/ЗДТГ-ын ня-бо/

Б. Энхчимэг /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Ж. Баасанцэрэн /Газрын даамал/

Ч.Гансүх/БОУБайцаагч /


Г. Цогтгэрэл/Хуримт багийн Засаг дарга/

Д. Отгонбаатар/Галуут багийн Засаг дарга/

С. Баярсайхан /Далан багийн Засаг дарга/

2. Орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэдээс авсан саналыг эрэмбэлж дүн мэдээг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг /Г.Болормаа/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

070000

C:/My document/ZDAD/

17 04 07

1/34

Шууд худалдан авалт хийх эрх олгох
тухай


Монгол улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг, Худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнэ тогтоосон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бог малын зөөврийн хашааг шууд худалдан авах эрхийг захиалагч, сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Болормаад олгосугай.

2. Бог малын зөөврийн хашааг малын тарилга, угаалга, ангилан ялгалтанд ашиглаж болохуйц зөөвөрлөж, угсрахад хялбар, чанарын шаардлага хангасан материалаар хийгдсэн хашаа худалдан авч, нийлүүлэгч талтай худалдах. худалдан авах гэрээ байгуулж ажиллахыг Тамгын газрын дарга Г.Болормаад үүрэг болгосугай.

3. Худалдан авч байгаа бог малын зөөврийн хашааны үнийг хууль тогтоомжид нийцүүлэн гэрээний дагуу санхүүжүүлэхийг нягтлан бодогч Д.Бямба-Очирт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

07000000

17 04 10

11/35

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, Сангийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 39 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны даргад: Г.Болормаа /Тамгын газрын дарга/

Нарийн бичгийн даргад: Р.Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/


Гишүүдэд: Б. Энхчимэг /МЭҮТ-ийн дарга/

Н. Бодьсад /Иргэний төлөөлөл/

О.Энхбат /Төрийн бус байгууллагын төлөөлөл/

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журамд нийцүүлэн шударгаар зохион байгуулж, үнэлгээний дүгнэлтийг захиалагч байгууллага болон оролцогчдод хүргүүлэхийг үнэлгээний хороо /Г.Болормаа/-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ЦЭДЭВСҮРЭН

0700101

17 04 10

1/36

Ажлын хэсэг байгуулах тухай

“Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3.-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сан болон малжуулах сангийн хөрөнгөөр хийгдсэн малжуулах ажлын эргэн төлөлтийг зохион байгуулж, сонгогдсон дараагийн өрхөд хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагчид: Г. Болормаа /Гамгын газрын дарга/

Гишүүдэд: Б. Энхчимэг/МЭҮТ-ийн дарга/

Р.Бүрэнжаргал /Санхүүгийн албаны дарга/


Тухайн багийн Засаг дарга

Тухайн багийн малын эмч

2. Малжуулах ажлын эргэн төлөлтийг гэрээний хугацаа дуусгавар болсон тухай бүрт нь зохион байгуулж, багаас сонгогдсон өрхүүдэд хүлээлгэн өгч, гэрээ байгуулж ажиллахыг ажлын хэсэг /Г.Болормаа/-т даалгасугай.

